

## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

### ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 31 ДҮГЭЭР ХУРАЛДААНЫ ТОЙМ

Хуралдаан 2013 оны 11 дугаар сарын 14-ний өдрийн 14 цаг 00 минутад эхэлж, 14 цаг 38 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 38 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Төрийн албаны зөвлөлийн дэргэдэх Эрүүл мэндийн яамны Салбар зөвлөлийн бүрэлдэхүүний тухай	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн "Гурав"-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 155 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдаанаар хэлэлцээд, гаргасан шийдвэрийг үндэслэн:</p> <p>Эрүүл мэндийн яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн даргаар тус яамны Төрийн захиргааны удирдлагын газрын хүний нөөцийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан мэргэжилтэн Сэнгээгийн Гантуяаг томилох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай	<p>Говьсүмбэр аймгийн Засаг дарга Л.Одсэрийн 2013 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн а/1415 тоот албан бичгээр Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах захиалга Төрийн албаны зөвлөлд ирсний дагуу сонгон шалгаруулалтыг 2013 оны 11 дүгээр сарын 14-ний өдрөөс эхлэн, Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон</p>

		шалгаруулалтыг 2013 оны 12 дугаар сарын 6-ны өдөр зохион байгуулахаар тогтлоо.
3	Зарим хүмүүсийг "Төрийн албаны тэргүүний ажилтан тэмдэг"-ээр шагнах тухай	<p>Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 71 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн албаны тэргүүний ажилтан тэмдгээр шагнах журам"-ын 3.3 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдаанаар хэлэлцээд гаргасан шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны чиг үүрэг, албан үүргээ үнэнч шударга, идэвх санаачилгатай, үр бүтээлтэй гүйцэтгэж, тогтвортой амжилт гарган төрийн албаны үйл хэрэгт бодитой хувь нэмэр оруулсан дараах нэр бүхий 6 төрийн албан хаагчдыг Монгол Улсын "Төрийн албаны тэргүүний ажилтан" тэмдгээр шагнасугай:</p> <p>2. Шагнагдсан хүн тус бүрийн тэмдгийг дагалдах мөнгөн шагнал (хоёр зуун мянган төгрөг)-ыг Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 71 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн албаны тэргүүний ажилтан тэмдгээр шагнах журам"-ын 4.2-т заасны дагуу шагнагдагсдад тухайн байгууллагаас олгох.</p> <p>3. Шагнагдсан нийт төрийн албан хаагчдад баяр хүргэж, ажлын амжилт хүсэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>

### ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

